



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/587

Номгон

Хорооны бүрэлдэхүүн шинэчлэн
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн төсөл сонгон шалгаруулах зээлийн хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилусгай.

Дарга- Аймгийн Засаг дарга

Гишүүд : -Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Баянхонгор аймаг дахь Монгол банкны захирал

Баянхонгор аймаг дахь Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Баянхонгор аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимын Тэргүүн

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч (Д.Батбаяр)

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч (Т.Баярмагнай)

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч (Б.Нацагдорж)

Нарийн бичгийн дарга (Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ийн гүйцэтгэх захирал)

2.Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихээр батлагдсан төсөв, санд багтаан төсөл хөтөлбөрийг журмын дагуу сонгон шалгаруулж, тухай бүр тайлагнан ажиллахыг ажлын хэсгийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

612201402

3. Сангийн төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зарцуулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг тайлагнан ажиллахыг Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ийн гүйцэтгэх захирал (Н.Баярсайхан)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-т үүрэг болгосугай.



ДАРГА *[Signature]* Д.МӨНХСАЙХАН